



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/22.

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны шалны модон материалыг худалдан авах ажлыг “Өндөр буянт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. “Өндөр буянт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, засварын ажлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны шалны модон материалыг худалдан авах зардалд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН